

Б. Түмэнжаргал

**МАНЖИЙН НОЁРХОЛ ДАХЬ ӨВӨР МОНГОЛ
(1636—1912)****1. Манжаас Өвөр Монголд тогтоосон захиргаа**

Манжаас Өвөр Монголын хавьд явуулсан бодлогын эхэн уеийн зорилт нь юуны өмнө Өвөр Монголд өөрийн ноёрхлыг бататгах улмаар түүний хүн, хүч, хөрөнгө баялгийг Хятад болон Монголын бусад хэсэг хийгээд Төвд зэрэг Азийн бусад орнуудыг байлдан дагуулах ажиллагаандаа шавхан дайчлахад чиглэж байв.

Иймээс Манжийн байлдан дагуулагчид Өвөр Монголыг эзлэх явцдаа «Монгол журган» (Монгол яам) гэгчийг байгуулахын хамт нэгэнт харьяандаа оруулсан Өвөр Монгол аймгуудыг манж хошууны (тугийн) маягаар 1634 онд зохион байгуулж эхлэсэн байна.

Манжийн төр 1638 онд Монгол яамыг өргөтгөн төвийн байгууллага болгон Монгол, Төвд, Уйгурын холбогдолтой хэрэг явдлыг эрхлэх байгууллага болгой өргөтгөж «Тулэрги голо бэ дасара журган» буюу «Гадаад Монголын Төрийг засах явдлын яам» (ГМТЗЯЯ) болгож түүний гол удирдах тушаалд манж хүмүүсийг ажиллуулдаг байлаа.

Манж нар анх өмнөт Монголын олон аймгийг манжийн харьяанд орсон байдлаар нь хоёр ангилж Манжийг эсэргүүцсэн буюу энд тэндээс нүүлгэн ирүүлсэн аймгуудыг «дотоод харьяаны хошуу» болгож манж хошууны зохион байгуулалтаар бүгдийн даргад захируулах болгожээ. Дотоод харьяаны хошуунд цахар найман хошуу, Хөх хотын Түмэдийн хоёр хошуу, нилээд сүүлд байгуулагдсан Хөлөнбуйрын шинэ хуучин барга, солон, өөлд хошууд, Бутха (Батган) нутгийн дагуур солони найман хошууг тус тус багтаан нэрлэх болжээ. Эдгээрийг Манж Чин улсын Цэргийн явдлын яам харьяалж байв.

Эсэргүүцэл ихтэй, сүүлд дагасан аймгуудыг «гадаад харьяаны» аймаг гэж нэрлэсэн бөгөөд үе улирах засаг ноёноор захируулдаг байсан Өмнөд Монголын зарим хошуудыг «дотоод засагт* хошуу» гэх бөгөөд бүгд 49 «дотоод» хошуу байлаа.

Өвөр Монголын дотоод засагт хошуудыг 1644—1661 онд бүгд зургаан чуулган болгож тус бүрийн чуулган нийлэх газрын нэрээр нэрлэв. Үүнд Жирэм, Зуу-уд, Зост, Шилийн голын дөрвөн чуулганыг зүүн дөрвөн чуулган. Улаанцав, Их-зуу хоёрыг баруун хоёр чуулган гэж нэрлэв. Чуулган бүр адилгүй тоотой хошуу сум болон хуваагдаж байв. Чуулган бүрд дарга, дэд даргыг тавьж чуулган даргын газар гэгчийг бий болгосон юм. Чуулган бүр 3 жил дутам нэг удаа хошууны засаг ноёд, бусад эрх баригчдын оролцоотойгоор чуулган чуулж харьяат олон хошууны тамгын газраас оруулсан хэрэг, тухайлбал цэргийн хэрэг, гэмт хэрэг, албан татвар тэгшитгэх зэрэг ажил хэрэг хэлэлцдэг. Шийдвэрлэж чадахгүй хэргээ Манжийн эзэн хааны төлөөний сайд, жанжин нарт уламжлан тэднээр буюу ГМТЗЯЯ болон Цэргийн явдлын яамаар шийд-

* Үүнээс уламжлан «Дотоод монгол» гэдэг нэр үүссэн юм. Ред.

вэрлүүлдэг байв. ГМТЗЯЯ-ны шууд харьяаны манж жанжин, захирагч сайд нарыг орон нутагт томилон суулгаж, чуулган дарга, хошуу захирсан засаг ноён хийгээд цэргийн хэргийг давхар хянаж байх болгосон юм.

Манжийн төрийн хуулинд Өвөр монголын нутгийн хилийг заахдаа: «Хорин таван аймгийн зах хязгаарын газар нь зүүн этгээд болбаас Мүгдэний Хар мөрөнд хүрнэ. Өмнөд этгээд болбаас урт хэрэм хотод (хятадын цагаан хэрэм-Ред.) хүрнэ. Умард этгээд болбаас говьд хүрнэ»¹ гэсэн байдаг.

Энэ бол нийт Өвөр Монголын нутгийн хил биш, Манжийн ноёрхлын зөвхөн эхэн үеийн дотоод засагт хошуудад холбогдох юм. Ар Монгол, баруун монголыг манж улс байлдан дагуулсны дараа Өвөр Монголын хошуу, чуулганы харьяат нутгийн зааг болон засаг захиргааны байгууллагад зарим өөрчлөлт нэмж хийсэн юм. Манжийн төр Өвөр Монголын засаг захиргааны хуучин хуваарь отог, түмэнг үгүй болгож, тэдгээрийн оронд байгуулсан захиргаа нь чуулган хошуудын зааг хязгаарыг нарийн тогтоож, чуулганы хошуудын ард иргэдэд хоорондоо чөлөөтэй шилжин явахыг хуулиар чангалан хориглосон тул тэдний хооронд улс төр, эдийн засгийн хэлхээ холбоо бараг үгүй, нэг нь нөгөөгөөсөө саланги байх болсон юм. Энэ нь Өвөр Монголчуудыг Манжийн эсрэг нэгдэж тэмцэх бололцоогүй болгох гэсэн хэрэг мөн. Нөгөө талаар Өвөр Монголын ноёд харьяат ард иргэдээ чангалан захирч манжийн төрд үнэнч зүтгэх нөхцөл бүрэлдүүлэхэд чиглэсэн байна. Монгол ноёдын хуучин цолыг өөрчилж ноёны 6 зэрэг, тайжийн 4 зэрэг тогтоосон агаад монгол ноёд тайж нар манжийн төрд аль хир үнэнч зүтгэж буй байдлыг харгалзан уг зэргийг анх шагнаж, Манж Чин улсын хууль ёсоор тогтоосон цалин фүнлү, дагалдах ард (хамжлага) олгох болсон² билээ.

Манж Чин улс 1648 оноос эхлэн Өвөр Монголын ноён, тайж, тавнан (эфү) нарыг жил бүр тусгай хуваариар Бээжинд жасаалуулж Манжийн эзэн хаантай шинэлэх ёс гүйцэтгүүлэх, цэргийн жагсаалыг шалгаж үзэх зэрэгт монгол ноёдыг оролцуулдаг байлаа. Энэ бүхэн бол Манжийн эзэн хаан, монгол ноёдын санаа сэтгэлийг нь биедээ татах, тэдний салж холдох харилхаг санааг дарах, бас тэр дашрамд тэдний ажиллагааг нь туршиж мэдэх, тэдэнд ая тал засахын тул элдэв бэлэг сэлт өгдөг байв. Тэрчлэн Манжийн эзэн хаан болон феодал язгууртныг Өвөр Монголын ноёд тайж нартай ураг төрлийн холбоотой болгох бодлого явуулж байсан юм. Энэ бүхэн бол Манж Чин улс Өвөр Монголд тогтоосон ноёрхлынхоо нийгмийн тулгуурыг бататгах Хятадын Мин улс ба Монголын бусад хэсэг зэргийг байлдан дагуулах түрэмгий ажиллагаандаа ашиглахын тул Өвөр Монголын феодалуудтай холбоотны харилцаа тогтоож байсныг харуулж байна.

Манжийн төр Өвөр монголд засаг захиргааны өөрчлөлт хийхдээ түүний цэргийн хүчийг өөрийн зорилгод ашиглах талаасаа их анхаарсан юм. Иймээс 18—60 насны, эрчүүдийг цэргийн бүртгэлд оруулж 150 цэрэг эр гаргаж чадах айл өрхүүдээс нэг сум байгуулж засаг захиргааны нэгж болгосон билээ. Эхний үед чуулган дарга нар жил бүр харьяат чуулган, хошуу, сумын цэрэг эрийг бүртгэн үздэг байлаа. Цэрэг эр дарагдуулбал хууль ёсоор хатуу цээрлүүлэх журам тогтоосон ажээ. Манж Чин улсаас Өвөр Монголд тогтоосон засаг захиргаа нь цэрэг-феодалын шинжтэй байлаа. Энэ дэглэм нь анх тогтоосон цагаасаа эхлэн Өвөр Монголын ард түмний эсэргүүцэлтэй тулгарсан юм.

¹«Да Цин улсын бүгд хууль» 94-р дэвтэр.

²«Зарлигаар тогтоосон Гадаад Монголын Төрийг засах явдлын яамны хууль зүйн бичиг». Цаашид хууль зүйн бичиг. 13-р дэвтэр.

2. Манжийн ноёрхлыг эсэргүүцсэн эхэн үеийн тэмцэл

Манжийн түрэмгийлэл ийнхүү лавширч байхад монголын бусад хэсэг ажиглагчийн байдалтай байгаагүй. Харин хамтын хүчээр манжийн түрэмгийлэгчдийг эсэргүүцэх зам хайж байв. Чухам энэ зорилгын үүднээс 1640 онд Ойрад Монголын зүүн гарын нутаг Тарвагатайн Улаанбураа гэдэг газар Ойрад, Ар Халх, Хөх нуур, Ижил мөрний торгуудын ноёдын чуулган болж монгол дахь феодалын бутрал, дотор зуурын зөрчлийг давж харь манжийн түрэмгийллийг тас цохихын тул монгол угсаатны хамтын чармайлтыг зохион байгуулах тухай асуудал хэлэлцсэн юм. Тус чуулган харийн түрэмгийллийг хамтын хүчээр эсэргүүцэх, дотоодын эв нэгдлийг бэхжүүлэхэд чиглэсэн «Монгол-Ойрадын хууль» хэмээх баримт бичгийг батлан гаргасан нь тухайн хэсэг үед Ойрад, Халхын улс төрийн үйл ажиллагаанд удирдамж болж байв. Халхын хан нар Манжийн захиргаанд орсон Өвөр Монголын зарим аймгуудыг алгуур эргүүлэн татах бодлого явуулж байв. Халхын Сэцэн хан Шолой (1577—1652) Манж Чин улсад эзлэгдсэн Өвөр Монголын Сөнид аймгийг Манжийн эсрэг хөдлөхөд идэвхтэй дэмжин ажилласны дүнд Сөнид аймагт Тэнгис ноёны удирдлагаар босогчид 1646 онд Халх Монголд нүүн ирсэн юм. Манжийн эзэн хаан эрх чин ван Тодоо гэгчээр удирдуулсан үлэмжхэн цэргийн Тэнгисийн удирдсан босогчдыг нэхүүлэхээр Халхын Сэцэн хан аймгийн нутагт оруулсанд босогчид Манжийн цэрэгтэй хэдэн удаа ширүүн тулалдсан боловч тухай бүр ялагдаж байв. 1646 оны намар Туул голын орчим Жажибулагийн газар шийдвэрлэх тулалдаан болоход Халхын Сэцэн хан, Түшээт хан нарын цэрэг Тэнгисийн босогчдыг өмгөөлөн Манжийн цэрэгтэй тулалдсан боловч амжилт олоогүй.¹ Ингэж Сэцэн хан Шолой, Түшээт хаан Гомбодорж (1594—1655) нарын Сөнид аймгийг дэмжих гэсэн оролдлого бол харийн түрэмгийлэлд эрсдэж буй Өвөр Монгол ах дүү нараа чөлөөлөх гэсэн ар монголчуудын анхны алхам байв.

Гэтэл Манж Чин улс үүнийг Халхын дотоод хэрэгт Оролцох шалтаг болгон ашигласан билээ. Лигдэн хаан нас барсны дараа түүний хүү эрх хонгор Эжээ албат иргэдийнхээ үлдэгдлийг толгойлон Манжийн эсрэг тэмцэж байгаад олзлогдсон юм. Манж нар Лигдэн хааны хүү Эжээд чин вангийн хэргэм шагнаж эзэн хааны гүнжийг (охиныг) хатан болгон өгч түүнийг хүндэтгэж байгаа дүр үзүүлж байсан боловч Сүнд Шарга гэдэг газар тусгай хяналтанд нутаглуулсан юм. Эжээ нас барсны дараа түүний дүү Авнайгаар чин вангийн хэргэмийг нь залгамжлуулж улсын гүнжтэй ураг холбуулж «улсын тавнан» болгожээ. Авнай, манжийн төрөөс олгосон зэрэг хэргэм хийгээд улсын гүнжид дургүй байсан тул 8 жилийн туршид эзэн хаанд ганц ч бараалхсангүй. Иймд манж нар түүнийг 1669 онд баривчилж бүх зэрэг хэргэмийг нь эвдсэн байна. Тэгэхдээ чин вангийн зэргийг Цахарт сууж байсан хүү Бүрнигээр нь залгамжлуулсан ажээ. Гэтэл Бүрни манжийн төрийн эсрэг эцэг өвгийн үзэл санааг өвөрлөж боломжтой нөхцөлд зэвсэглэн босч Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцэх, өвөг эцгийнхээ төрийн тамгыг олж авч хаан болохыг хүсч байжээ.²

Тэр өөрийн хүү Лувсан, Найманы ван Жамсантай хамтарч сэмээр цэрэг бэлтгэж, 1675 онд Манжийн эсрэг хятадын өмнөт нутагт бослого гарсан үеийг тохиолдуулан хөдөлсөн байна. Бүрнигийн удирдсан бослого нь ар талын туслах хүчин дутагдсан хийгээд бас дотроо хагаралдсан зэрэг шалтгаанаар арга буюу ялагдахад хүрсэн ажээ. Бүрнигийн удирдсан

¹Галдан. Эрдэнийн эрих. УБ., 1960, 91-р тал.

²Болор толь. II дэвтэр.

босогчид 6 сар гаруйн хугацаанд манжийн цэрэгтэй баатарлагаар тулалдсан боловч Бүрн Ванг амь үрэгдсэний дараа давуу хүчинд цохигдсон ажээ.

Манжийн захиргаа үүнээс хойш цахарын нутгийг Адуун сүргийг хамаарах яаманд захируулж, ард иргэдийг нь Баян сүм (Сюаньхуа) Датунгийн араар шилжүүлэн суулгаж Манжийн хошуу захирагч сайдад захируулан найман тугийн зохион байгуулалттай болгосноор цахар гэдэг нэр Манж Чин улсын албан бичиг баримтаас хасагдах тийш хандсан амуй¹.

Манжийн түрэмгийлэгчид Өвөр Монголыг эзлээд Ар Халх, Баруун Монголтой байлдах бэлтгэлээ базааж байхад Өвөр Монголчууд түүнд оролцон туслахаас зайлсхийх, татгалзах зэрэг олон хэлбэрээр эсэргүүцэж байжээ. Ялангуяа 1690 онд Ойрадын Галдан (1651—1697) бошогт хан, Халхын феодалуудыг нэхэж Үзэмчний нутагт нэвтрэн ирээд Манжийн цэрэгтэй тулалдахад тэр нутгийн ардууд олон хэлбэрээр түүнд шууд тусламж дэмжлэг үзүүлж байжээ. Галдан бошогтын цэрэг 1695 онд Ар Халхын Баян улаанд дахин орж ирэхэд Найман аймгийн ноён Мод-Очин манжийн талд цэрэг гаргаж өгөхөөсөө татгалзаж байжээ. Ер нь манжийн эсрэг Галдангийн тэмцлийг Өвөр Монголчууд дэмжиж байсан баримт цөөнгүй бий.

Манж Чин улс арга хүчийг хослон хэрэглэж Ар Монгол буюу Ар Халхыг 1691 онд эзлэсний дараа Монголын тусгаар тогтнолын сүүлчийн голомт нь Баруун Монгол буюу Ойрад (Өөлд)-ын зүүн гарын хант улс болж үлдсэн юм.

Манжийн цэрэг 1731 онд Ойрадын Галданцэрэнгийн (1727—1745) эсрэг байлдахад Өвөр Монголын хошууны занги Бандь, Сод нарын зэрэг хүмүүс оролцохоос татгалзаж, өөрсдийн 500 гаруй цэргээ дагуулан Галданцэрэнгийн талд орсон ажээ. Мөн энэ дайнд оролцуулахаар манжийн захиргаа Ордосоос 3000 морин цэрэг дайчласны 400 гаруй нь монгол ах дүү нартайгаа байлдахаас татгалзаж зам зуураа зайлсан байна. Тэрчлэн барга цэргүүд байлдаанаас зайлсхийж Орос улсын нутагт дүрвэн орж байв²

Түүнчлэн баруун Монголд Амарсанаа (1718—1757)-гийн удирдлагаар гарсан тусгаар тогтнолын зэвсэгт тэмцлийг даруулахаар Өвөр Монголоос дайчлан аваачсан цэргийн зарим монгол ноёд мөн байлдахаас татгалзаж тулалдааны талбараас цэргээ шууд татан зайлж байжээ.

Эдгээр баримт бол Өвөр Монголчууд харийн түрэмгийлэгч Манжийн ноёрхлыг янз бүрийн нутагт элдэв хэлбэрээр эсэргүүцэж байсны зөвхөн зарим жишээ юм. Харин манж чин улс монголын бусад хэсгийг эзлээд дарангуйлах дэглэмээ чангаруулсны улмаас нэг хэсэг үед ард олны эсэргүүцэл намжуу нуугдмал байдалд орсон ажээ.

3. XVII—XIX зууны үед Манж Чин улсаас Өвөр Монголд явуулсан нийгэм-эдийн засгийн бодлого

Өгүүлэн буй үед Өвөр Монголын нийгэм нь аанай л феодалын байгуулалттай байлаа. Манж Чин улсын ноёрхолд байсан тэр үед монголчуудын засаг захиргааны байгуулал, ангийн бүрэлдэхүүн, нийгмийн ухамсар, уламжлалт аж ахуйд гарсан зарим өөрчлөлт нь түүнээс Өвөр Монголын хувьд явуулсан нийгэм-эдийн засгийн бодлогоор тайлбарлагдана. Манж Чин улс Ар Монголыг байлдан дагуулаад, баруун монголыг эзлэх бэлтгэл хийх зуураа Өвөр монголын зарим нутагт засаг захиргааны нэмэлт өөрчлөлт хийж 1725 онд Хөх нуурын монголчуудыг Хошууд, Торгууд,

¹Юй Юан-ань. Дурдсан зохиолын 118-р тал.

²Юй Юан-ань. Мөн тэнд.

Өөлд, Чөрөс зэрэг 30 хошуу болгон зохион байгуулж, манжийн хэрэг шийтгэгч сайдад захируулсан. Түүнчлэн Алашаад нэг хошуу байгуулснаас гадна цахарт Өөлд нэг хошуу хавсаргасан ба 1732 онд Хөлөнбуйрт Солон 8 хошуу байгуулснаас гадна Манжийг эсэргүүцсэн хөдөлгөөний үед тарж сарнисан барга ард иргэдийг цуглуулж хошуу сумын зохион байгуулалт оруулж Мээрин занги гэгчид харъяалуулсан юм.

Манжийн байлдан дагуулагчдаас Өвөр Монголд эхлээд байгуулсан, сүүлд нэмж байгуулсан засаг захиргааны аль нь ч нийт Өвөр Монголыг нэгтгээгүй. Харин олон жижиг хошуу, сум болгон бутаргаж манж хэдэн сайд жанжин нарын харьяанд оруулсан нь харийн түрэмгийлэгчид тус оронд ноёрхлоо бат бэх байлгахын тул сонгож авсан нарийн аргын нэг байлаа.

Монгол орон манжид эзлэгдэхээс өмнө феодалын байгуулалтай байсан. Харин түүний ноёрхолд орсноос хойш уг нийгмийн харилцаа олон талаар нарийсч ард ангийн байдлыг ихэд хүндрүүлж байв.

Өвөр Монголын нийгмийн үндсэн ангиуд нь феодалын анги, ард анги байв. Феодал анги нь олон зэрэг дэвийн ноён, тайж, тавнан зэрэг хар феодал, хутагт, засаг лам болон хүрээ хийдийн дээд лам нар зэрэг шар феодалаас бүрэлдэж байлаа. Чин улсын бүх хууль тогтоомж нь феодал ангийн эрх ашгийг бүрэн илэрхийлсэн агаад ард анги нь «хамжлага ард», «албат сум-ард», «шавь ард»-аас үндсэндээ бүрэлдэж байлаа.

Феодалын дарлал мөлжлөгийн эдийн засгийн үндэс нь үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл болох газар үлэмжхэн малыг феодал анги өмчилж байсанд оршино.

Феодализмын эдийн засгийн эл үндэс монгол оронд анх феодалын харилцаа ялсан үеэс бий болсон билээ. Манжийн ноёрхлын үед монголын нийт газар нь манж улсын эзэмшилд багтаж байв.

Тэр үед монголын газрын дээд эзэн нь манжийн эзэн хаан болж байв.

Манжийн эзэн хаанаас хошуу нутаг захирах эрх олж авсан засаг ноён, харьяат хошууныхаа ардаас Манж Чин улсад залгуулах олон зүйлийн албыг цаг тухайд нь залгуулахын зэрэгцээгээр хошууны нутгийг захирах эрхээ ашиглан ард олныг мөлжиж байжээ. Хошууны засаг ноён аль шилдэг ус бэлчээрийг эзэмшихээс гадна харьяат хошууны бэлчээрийг хуваарилан зохицуулдаг эрхтэй байжээ.

Чин улсын хуулиар ардууд нэг хошуунаас нөгөө хошуунд дураараа шилжихийг хатуу хориглож байсан тул хэрэг дээрээ тэднийг тодорхой нутагт хадаж, аль нэгэн феодалд гарцаагүй мөлжигдөх болгосон ажээ. Ардын хувийн аж ахуй нь феодалын том аж ахуй оршин тогтнохын нэг нөхцөл болж байв.

Чин улсын хууль ёсоор бүх зэрэг дэвийн тайж, ноёд тогтоосон тооны хамжлагатай байсан. Хамжлага ардын гол үүрэг бол харьяат эзэндээ үе улиран үйлчлэх явдал мөн. Феодалууд хамжлага ардыг аливаа ажилд зарцлаж, хэрэгцээтэй зүйлээ тэднээс татварлаж авч болно. Мөн тэднээс заримыг нь аль нэгэн хутагт хувилгаадад «шавь» болгон өргөх, охиноо мордуулахад «инж» болгон өгөх мэдэлтэй байжээ. Иймд хамжлагын эзэд, хамжлага ардаа дур мэдэн алахаас бусдаар хагас өмчилж байсан амуй.

Чин улсын сүүлийн улиралд засаг бус ноёд тайж нар аажмаар хамжлагагүй болсон юм.

Албат сум ард бол манжийн төрийн албыг залгуулдаг бөгөөд ард ангийн дийлэнх олонхи болж байлаа. Тэд нь хошуу сумын зохион байгуулалттай байсан бөгөөд цэргийн алба, зах хязгаарын харуулын алба, албан тарианы ажил, олон замын өртөө, Манжийн эзэн хааны сүргийг адуулах, бүх засаг захиргааны байгууллага ба тэдгээрийн албан хаагч-

дын зардлыг нийлүүлэх зэрэг гол үүрэгтэй байжээ. Эдгээр албыг албат сум ард өөрсдийн мал хөрөнгө ба биеэр зүтгэн хааж байв. Бас харъяат хошууны засаг ноёдод албатын хувиар татвар төлж аж ахуйд нь зүтгэж байсан тул албат ардын байдал хамжлагаас илүү хүнд байв. Манж Чин улс хууль ёсоор монгол ноёдын албат ардаасаа гувчуурлан татварлах зүйлд нарийн хэмжээ тогтоосон юм.

Засаг ноёд албат нараас хуулинд заасан хэмжээнээс хэтрүүлэн дураараа гувчуурлах явдал түгээмэл байв. Ноёд нь албат ардаас бие зүйлээр алба авах, хөлсгүй ажил хийлгэхээс гадна XIX зууны эхэн үеэс мөнгөөр татвар авдаг болжээ.

Албат сум ард ийнхүү засаг ноёдод алба гувчуур төлөөд зогссонгүй. Тэдний гол үүрэг бол хошуу, чуулганы хэмжээний улсын чанартай албыг залгуулах явдал юм.

Манжийн эзэн хаан, хошууны тамгын газраас алс зайтай оршдог 800-гаас доошгүй тооны шавьтай хутагт нарт харъяат шавь нараа засаг ноёны адил захирах эрх бүхий тамга олгодог¹ байжээ.

Өвөр Монголд нийт 170 гаруй их бага хутагт хувилгаад байсны дотор XVII зууны сүүлчээр засаг да лам, эзэн хааны багш (гоши) хэмээн өргөмжлөгдөж Долоннуур, Бээжингийн тэргүүн лам болсон Жанжаа хутагт Агваанчойндон (1642—1714)-гоос эхлээд түүний дараах дүрүүд хамгийн том нь байлаа. Тэд бол Манжийн төрийн дуулгавартай зарц болж байв. Чин улсын ноёрхлын сүүл үед Өвөр Монголд 1166 хүрээ хийд байлаа.

Хутагт хувилгаан, хүрээ хийдийн дээд мяндаг тушаалын лам нар бол шар феодалууд мөн. Иймд манжийн төр тэднээр дамжуулан өөрсдийн ноёрхлыг Өвөр Монголд бататгаж байсан амуй.

Чуулган хошуу бүхэнд тахилгат уул овоо гэж байсан. Түүнийг жил бүр 1—2 удаа тахих (тайх)-ын тул ард олны хөрөнгийг бүрэлгэн сүйтгэж тэднийг бөө мөргөл, шарын шашны бурангуй суртлаар мунхаруулж байв. Шарын шашин ертөнцийн амьдралд идэвхигүй хандаж аливаа дарлал мөлжлөгийг хүлцэн тэсвэрлэхийг номлож байснаараа нийгмийн ба үндэсний дарлалын эсрэг ард олны тэмцлийг мохоож байв.

Иймээс манжийн төр бүх нийтийг үзэл суртлын талаар шарын шашны номлолын хүлээсэнд байлгаж монголчуудын биеэ даасан уламжлалт соёл, үндэсний ухамсрыг зориуд боогдуулах бурангуй бодлого явуулсны дүнд монгол айл бүхэн бурхан шүтэж бараг хүн болгон лам багштай болжээ. Өвөр Монголын бүх эрэгтэйчүүдийн 30—65 хувь нь хүүхэд ахуй цагаасаа сүм хийдэд шавилан сууж шашны номлолыг харь төвд хэлээр заалгаж бясалган, нийгмийн тустай хөдөлмөрөөс ангид амьдардаг байсан нь нийгмийн үйлдвэрлэх хүч, хүн амын өсөлтөнд нэн халгаатай байжээ.

Манж ноёрхогчид монголчуудыг зөвхөн бэлчээрийн мал аж ахуйтай нь байлгах бодлого явуулж байлаа. Гэтэл манжийн төр Өвөр монголыг чуулган, хошуу, сум, болгон бутаргаад хошуу сум өөр хоорондоо чөлөөтэй харилцахыг хориглож байсан нь ялангуяа мал аж ахуйн ашиг шимийг дээшлүүлэх дэвшилт арга барил нэвтрүүлэх бүх боломжийг боож байлаа. Тэрчлэн манжийн түрэмгий дайны бэлтгэл, олон зүйлийн алба гувчуураас болж мал аж ахуй өөдлөн хөгжиж чадахгүй байв. XVII зууны үед Өвөр монголын зарим нутагт монголчууд хуучин болхи багаж, арга ажиллагаагаар бага зэрэг тариа ногоо тарьж байлаа. Тэр нь мал ахуйд туслах чанартай байв. Манж нар, монголчууд хятадтай эвсэн нэгдэж эсэргүүцэхээс болгоомжлохдоо хятад иргэд монгол нутагт ирж газар хагалбарлан тариалахыг хуулиар хатуу хориглож байсан хэдий бо- 1 2

¹«Хууль зүйн бичиг» 60-р дэвтэр.

²«Хууль зүйн бичиг» 10-р дэвтэр.

ловч Өвөр Монголын тариалангийн ажилд багагүй ахиц гарч байв. Тариалангийн хөгжилт нь нутаг нутагт харилцан адилгүй байв.

Манж Чин улс цэргийн хэрэгцээнд зориулж Өвөр Монголын баруун хойт нутагт XVIII зууны эхээр албан тариалан үүсгэж хятад иргэд ба монголчуудын хүч хөдөлмөрийг шавхан дайчлах болсон ажээ.

Ан агнах явдал Өвөр монголчуудад бас хавсрага аж ахуй болж байлаа. Орчон, Дагуур, Солоны зарим анчид ан авыг дагнан эрхлэж байжээ. Манжийн эзэн хаан монголоос үнэт ангийн арьсаар алба авдаг тул зарим аймаг хошуу түүнийг бэлтгэх зорилгоор Халуун голын хавь зэрэг газар ав хомрого зохион байгуулдаг байв.

XVII—XX зууны үед Өвөр монголд хот, суурин газар их төлөв худалдаа, гар урлал, шашны чиглэлээр үүсч байлаа. Энэ нь Манж Чин улс хятадын худалдаа, гар урлалын хүмүүс Өвөр Монголд ирж ажиллахыг аль нэг хэмжээгээр зөвшөөрч байсан. Мөн монголд шарын шашин дэлгэрэх явдлыг элдвээр дэмжин тэтгэж байсан төрийн бодлоготой шууд холбоотой юм.

Монголчууд худалдааны хэргээр хятад газар зорчих, өөрсдөө худалдаа, гар үйлдвэр эрхлэн хөгжүүлэхийг элдвээр боогдуулж байсан тул монголын худалдаа, гар урлал өгүүлэн буй үед зөвхөн орон нутгийн хэмжээнд түгжигдэж хэрэг дээрээ зогсонги байдалд орсон юм. Чин улс бусад орныг байлдан дагуулах, эзлэгдсэн ард түмний эсэргүүцлийг дарахдаа, монголын эрчүүдийг үргэлж дайчилж байсан болохоор монголчууд худалдаа, гар урлал эрхлэх нь хомс байлаа. Нөгөө талаар Манж Чин улс түүнийг хязгаарлах бодлого хэрэглэж байснаас хятад худалдаачин, гар урчууд түр хугацаагаар боловч Өвөр Монголд ирэх нь жилээс жилд олширч монголчуудын уламжлалт гар урлал, худалдаа, арилжаанд цохилт болж эхлэв. Хятад худалдаачид Хөх хот (Гуй хуа), Чуулалт хаалга (Чжанцзякоу) Долоннуур зэрэг хотод голлон төвлөрч байв. Эдгээр хот дахь Хятадын суурин пүүсний тоо жилээс жилд олширч байсан амуй. Жишээ нь: Чуулалт хаалга хотод 1721 онд 80 пүүс байсан бол 1820 онд 230 болж өссөн ажээ.¹ Бусад хотуудад энэ мэтээр хятад пүүс нэмэгдэж түүнийг дагалдан зочид буудал, янз бүрийн үйлчилгээний газар зэрэг хятад байгууллага олон ажиллаж байжээ. Пүүснүүд хэсүүл худалдаачдыг чуулган, хошуудад явуулж худалдаа арилжаа хийлгэдэг байлаа. Тэгэхдээ хүрээ, хийд, чуулган даргын газар, хошууны тамгын газрын дэргэд дэлгүүр нээж ажиллуулдаг. Монголчуудад бараагаа зээлээр өгөх, мөнгө зээлдүүлэх болсон нь ард олныг мөлжих хамгийн ноцтой арга болж байв. Хятад худалдаачид өр, зээлийн хүүгээс хүү үржүүлэх тул Чин улсын ноёрхлын үед Өвөр Монголын бүх хошуу хятадын пүүсэнд үлэмжхэн өртэй байв. Феодалууд өөрсдийн өрийг хамжлага албат ардаар төлүүлэх явдал түгээмэл болсон нь ард олны амьдралыг ихэд хүндрүүлэв.

Худалдааны пүүс чуулган хошуу бүрд үлэмжхэн малтай болоод түүнийгээ монголчуудаар хариулгаж байв. 1892 онд зөвхөн Жирэмийн чуулганы нутагт Шаньси мужийн худалдаачдын мал гэхэд 30 түмэн толгойд хүрч байв.²

Хятадын худалдаа, мөнгө хүүллийн капитал нь Өвөр Монголын хувиа аргацаадаг эдлэхүүний аж ахуйн үндэс суурийг хөндөн улмаар таваар мөнгөний харилцаа үүсэх явдалд зарим талаар түлхэц болсон боловч. үйдлвэрлэлийн шинэ аргыг буй болгоогүй харин үйлдвэрлэлийн аргыг улам доройтуулж байв. К. Маркс мөнгө хүүлэгч худалдааны капиталын

¹ Ш. Таяма. Син жидай ни океру моконо ся кай сейдо (Чин улсын үеийн Монголын нийгмийн байгуулал), Токио, 1954. 280-р тал.

² Юй Юан-ань. Дурдсан зохиол. 121-р тал.

шинж чанарыг тодорхойлохдоо: мөнгө хүүлэл нь Азид байгаа хэлбэрээрээ эдийн засгийг улам унагааж, улс төрийн ялзралыг буй болгохоос өөр ашигтай юу ч хийхгүйгээр маш удаан тогтоож чадах юм»¹ гэсэн билээ.

Манжийн төр худалдаа-гар урлалын зэрэгцээгээр 1662—1722 оны үеэс хятад иргэдийг Өвөр Монголын нутагт хавар ирүүлж тариа тариулан ургацыг нь хураагаад намар буцах журам тогтоосон байна. Тэр үед жилдээ зөвхөн 800 хүн Өвөр монголд ирэхийг зөвшөөрч байсан мэдээ бий². Гэтэл аажимдаа хятадын дотоод олон мужаас газаргүй иргэд Өвөр Монголд ирж атар газар эзэмшин амь улжих гэсэн эрмэлзлэлийг манжийн төр улам бүр ихэсгэн дэмжих болсон ажээ.

Манж Чин улсыг эсэргүүцсэн тэмцэл хятадад байн байн гарч байсан тул Өвөр Монголд түр ирсэн хятад иргэдийг манжийн төр албадан нутагт нь буцаахаа аажмаар больж хятад иргэдийг захирах «тин» хэмээх засаг захиргааны байгууллагыг 1723 онд Халуун гол, Хөх хот орчимд байгуулаад түүнээс хойш олон газарт нэмж байгуулав.

Манж Чин улсын ноёрхлын сүүл үеэс Өвөр монголд хятадын колоничлогчид үй олноороо нэвтэрч ирэх болсон нь монголчуудын аж байдалд сүрхий дараас болох болсон ажээ.

XVIII зууны эцэс XIX зууны эхнээс өрнөдийн капиталист орнууд Манж Чин улсыг түрэмгийлж эхэлжээ. Манж Чин улс нь өрнөдийн хөгжингүй орнуудаас нийгэм-эдийн засгийн хөгжлийн хувьд бүтэн нэг нийгмийн байгууллаар хоцорч байлаа. Манжийн байлдан дагуулагчид монгол, хятад, төвд, уйгур, солонгос зэрэг харь олон угсаатныг ноёрхон дарангуйлж байхын тул тэдний нийгэм-эдийн засгийн хөгжлийг зориуд боогдуулах бодлого явуулж байсан нь эцсийн эцэст харийн түрэмгийлэгчдээс улс орноо батлан хамгаалах чадваргүй болгосон ажээ.

Иймээс Манж Чин улс өрнө дорнын хүчирхэг гүрнүүдийн эрхшээлд орж эхлэсэн байна.

Гадаадын хөрөнгөтөн улсын ашиг хонжоо эрсэн этгээдүүд Өвөр Монголд нэвтрэн орж төмөр зам тавьж нутгийн баялгийг ашиглаж эхлэсэн билээ. Тэд өөрсдийн түрэмгийллийг зөвтгөх үзэл суртлын зэвсэг бэлтгэх зорилгоор Өвөр Монголд христосын шашин номлогчдыг ирүүлж сүм байгуулан өөрсдийн шашинд хятад монгол хүмүүсийг оруулан авч байх болжээ. Анх 1830 оны үед францын хар лам цахарт сэм ирж, өөрсдийн суртлыг номлож улмаар сүм байгуулж эхлэсэн ажээ. Тэд зөвхөн сүм байгуулж шашин номлоод зогссонгүй, үлэмжхэн газар эзэмшиж зарим нутагт мөнгө хүүлж байх болсон байна. XX зуун гарах үед Өвөр Монголын зөвхөн баруун хэсэгт нийтдээ 5 сая му* газар эзэмшсэн гадаадын 265 сүм байсан байна. XIX зууны 90-ээд он болоход империалист гүрнүүд Чин улсын бүх нутгийг нөлөөнийхөө хүрээнд хувааж дууссан ажээ. Энэ тухай В. И. Ленин хэлэхдээ: «Европын засгийн газрууд удаа дараагаараа хятдын газрыг «түрээслэн авах» өөрөөр хэлбэл дээрэмдэх явдлыг хичээнгүйлэн хийж байсныг үзэхэд хятадыг хувааж авах тухай үг яриа гарсан нь учиртай юм»³ гэжээ.

Европ, Америкийн капиталистууд Чин улсад гүн нэвтрэхийнхээ хамт Өвөр Монголын баялаг түүхий эдийн их нөөцийг тонон дээрэмдэж эхлэсэн юм. 1896 онд Хаант Оросын засгийн газар Чин улс хоёр Азийн эх газрыг харийн шинэ мөлжлөгөөс хамгаалахын тулд холбооны гэрээ байгуулж улмаар Өвөр Монголын зүүн хойт нутгаар дамжуулан Влади-

¹К. Маркс. Капитал. т. III. Л., 1949, 611-р тал.

²Ш. Таяма. Дурдсан зохиолын 339-р тал.

* 666,7 ам метр талбайг 1 му гэдэг.

³В. И. Ленин. Зохиолууд, 4-р боть, 373-р тал.

восток руу төмөр зам тавих эрх олж аваад тэр үүргийг хоёр улсын хувь нийлүүлсэн банк эрхлэн гүйцэтгэх болсон юм.

Энэ үед Японы империализм ч идэвхжиж зүүн зүгээс Азийн эх газрын гүн рүү түрэлт хийж Өвөр Монголд шууд өнгөлзөж эхэлсэн ажээ.

Манж Чин улсаас монголын хувьд явуулсан нийгэм-эдийн засгийн бодлого нь бүхэлдээ тус орны феодалын байгууллыг дагтаршуулахын хамт Манжийн улс төрийн ноёрхлыг бататгах зорилгын үүднээс хийсэн зарим өөрчлөлт нь монголын хөгжил дэвшилд түлхэц болсонгүй, харин яваандаа харь хятад болон империалист гүрнүүдийн давхар, давхар дарлал мөлжлөгт өнө удаан эрсдэх үүдийг нээж өгсөн юм.

Иймээс Манж Чин улсын нийгэм-эдийн засгийн бодлого Монголын түүхэнд нэн харгис үүрэг гүйцэтгэсэн нь илэрхий.

4. XIX зууны үед Өвөр Монголын ард олон харийн колоничлолыг эсэргүүцсэн нь

Манж Чин улсын бодлогыг монголд хэрэгжүүлэгчид нь монголын засаг ба засаг бус ван гүн, дээд лам нар, дээгүүр зэргийн тайж, тавнан нар байв. Монголын ард түмэн дотоодын феодалуудын дарлал мөлжлөгийг номхон хүлцэнгүй хүлээж байсангүй. Тэднийг эсэргүүцэн янз бүрийн хэлбэрээр ангийн тэмцэл хийж байсан бөгөөд харъяат ноёноосоо нүүн зайлах, алба гувчуур төлөхгүй байх, шунахай ноёдтой заалдах явдал XVIII зууны сүүлч XIX зууны эхээр ард олны тэмцэлд зонхилох хэлбэр болж байв. Монгол феодалыг эсэргүүцсэн ард олны тэмцэл гүнзгийрэхдээ Манж Чин улсын дарангуйллыг эсэргүүцсэн шинж чанартай болж хувирдаг байв.

Манж Чин улс бүх монголыг эзлэснийхээ дараа, Өвөр Монголтой холбоотны маягаар харилцаж байсан бодлогоо алгуур өөрчилж хятадын худалдаачид ба тариачин иргэдийг юуны урьд Өвөр Монголын уудам нутагт нэвтрэн ирж колоничлохыг зөвшөөрөхийн сацуу гадаадын империалист гүрнүүдэд найр тавин өгсний улмаас Өвөр Монгол дахь ангийн тэмцэл нь харийн түрэмгийллийг эсэргүүцэх үндэсний эрх чөлөөний тэмцэлтэй хутгалдаж жилээс жилд улам хурцдаж байх болсон байна.

XIX зууны дунд үед Өвөр Монголд гарсан ард олны тэмцлийн шинэ нэг хэлбэр бол «дугуйлан» юм. Феодалын дарлал, харийн түрэмгийллийг эсэргүүцэх үзэл санаа бүхий хүмүүс аглаг газар цугларч дугуйлан суугаад өөрсдийн бодол, нутгийн байдал дарлал мөлжлөгийн хүндийг харилцан ярилцаж, шүүмжлэн хэлэлцээд үндэсний ба нийгмийн дарлал мөлжлөгийн эсрэг тэмцэх арга хэлбэрээ тогтоодог болжээ. Тэд өөрсдийн гаргасан шийдвэр, хошуу тамгын газар буюу чуулганд өргөх гомдол, заргын бичиг тэргүүтэнд гарын үсгээ мөн л дугуйруулан зурдаг байжээ. Энэ нь оролцогчид цөм адил эрхтэй гэснийг илтгэсэн санаа бөгөөд бас ч хэн удирдаж байгаагаа нууцласан арга байв. Ер нь ийм дугуйлан нилээд ардчилсан шинжтэй байжээ.

Өвөр Монголд эл хөдөлгөөн анх Их зуугийн чуулганы Ордос нутгийн монголчуудын дунд 1858 онд Үшин хошуунд гарчээ. Дараа нь 1866 онд Отог хошуунд дэлгэрсэн. Ордост гарсан ард олны энэ тэмцэл олон жил үргэлжилж орон нутгийн феодалын дарлал хийгээд мөн тэднээс нутаг бэлчээрээ хятад иргэд болон харийн түрэмгийлэгчдэд худалдаж, ашиг завшаан хөөцөлдөж байгаа явдал хийгээд харийн зандалчдын бурангуй үйл ажиллагааг эсэргүүцэж байжээ. Энэ нутагт дугуйлангийн хөдөлгөөн 1858—1891 онд хүчтэй өрнөөд чуулган даргын газраас буулт хийлгүүлж байжээ.

Зарим нутагт ард олон шууд зэвсэг барин тэмцэж байлаа. Тухайлбал, 1864—1868 онд Зостын чуулганы Харчин баруун гарын хошуунд Бай-

линга, Мялсэнгэ нарын удирдлагаар, мөн чуулганы Түмэд хошуунд Чойжинтой, Намсрай нарын удирдлагаар феодалын дарлал, хүнд алба гувчуурыг эсэргүүцсэн бослого тус тус гарч Чин улсын цэрэгтэй тулалдаж байгаад ялагдаж байжээ.¹ Эдгээр бослогын заримд хятад иргэд монголчуудтай хамтран тэмцэж байжээ.

XIX зууны 80-аад оноос эхлэн Өвөр Монголын ард түмэн колоничлогч хятадууд болон тэдэнд нутгаа найр тавин өгсөн буюу худалдсан ноёд феодалын эсрэг тэмцэх явдал их өрнөсөн ажээ.

1891 онд Зуу-удын чуулганы Найман хошууны ардууд бэлчээр нутгаа хамгаалж хятад иргэдээр газар хагалбарлуулан тариалуулахыг эсэргүүцсэн тэмцлийг хэдэн жил үргэлжлүүлэн хийгээд тус хошууны нутгийг хагалбарлан тариалах явдлыг хэсэг хугацаанд болиулж байсан байна.² XIX зууны эцсээс Манж Чин улс «иргэдийг нүүлгэж, хязгаарыг төгөлдөржүүлэх» гэгч бодлого явуулсан нь чухамдаа монголчуудын хувьд тэдний өргөн уудам газар, хөрөнгө баялгийг нь цөлмөж хүчээр хятадчилах шинжтэй байв.

Иймээс монголчуудын эрх чөлөөний тэмцэл нь зөпхөн Чин улсын ноёрхол төдийгүй хятадын колоничлогчдын эсрэг бас хандаж иржээ.

Өвөр Монголчууд тэр үед зөвхөн Манж-хятадын колоничлогчдыг ингэж эсэргүүцэж байгаагүй бас харийн түрэмгийлэгчдийн гар хөл болсон шашин номлогчдыг анх нэвтэрч ирэх үеэс нь эсэргүүцэж байлаа. Харин 1899—1900 онд Манж Чин улсын бараг бүх нутагт харийн түрэмгийлэгчдийг эсэргүүцсэн «Ихэтуанийн» хөдөлгөөн өрнөсөн үед Өвөр Монголчууд гадаадынхны байгуулсан сүм, шашин номлогчдын эсрэг турхиран босч тэмцсэн ажээ. Ялангуяа Өвөр Монголын баруун хэсгийн ард олон тухайлбал Ордост католик шашны сүм олныг устгаж шашин номлогчдыг хядсан. Гэтэл Ихэтуаний хөдөлгөөн дарагдсаны дараа империалист гүрнүүд, түүний хариуд Өвөр Монголоос их хэмжээний өр нэхэж, газрыг нь төлбөрт барьж авсан ажээ. Жишээ нь: Их-зуугийн чуулганы Далд хошуунаас 2095 цин* газрыг 14 түмэн лан мөнгөөр Алаша, Отог зэрэг хэдэн хошуунаас энэ мэтчилэнгээр бодож үлэмжхэн сайн газрыг төлбөрт авсан амуй³.

Түүхэн ийм шинэ нөхцөлд Өвөр Монголын ард түмний тэмцэл гадаадын империалист гүрнүүд хийгээд Манж-хятадын колоничлогчдын эсрэг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний шинжтэй болж байжээ.

Ер нь монголчууд Манжид эзлэгдсэнээсээ хойш түүний захиргааг ямагт харилцан эсэргүүцэж байсан нь Өвөр Монголчуудын оюуны соёлд мэдэгдэхүйцээр туссан байдаг. XVII—XIX зууны үед Өвөр Монгол зохиогчдын бичсэн түүхийн олон сударт Монголчууд анхнаасаа Манж, хятадаас ангид биеэ даасан соёл, иргэншил, төр ёстой байсаар ирснийг дахин давтан нотолсон байдаг. Ялангуяа Манж нар хятадад уусч, хятадын ноёлогч ангийн этгээд Чин улсын төрийн бодлогод идэвхтэй үүрэг гүйцэтгэх болсон XIX зууны дунд үеэс Манж-хятад колоничлогчдын үндэсний дарлал хийгээд монголын феодалын мөлжлөг, шарын шашны бурангуй суртлыг илэрхий шүүмжлэн эсэргүүцэх явдал ихэд өсч ирэв. Үүний томхон төлөөлөгч нь зохиолч Ванчинбал (1794—1847), түүний хүү сэтгэгч, зохиолч Инжиннаш (1837—1892) болон яруу найрагч Иш-

1Юй Юан-ань. Дурдсан зохиолын 148-р тал.

2Жачисэчин. Мэнгүчжи цзинь си (Монголын эрт эдүгээ), Тайбэй, 1953. 189—190-р тал.

*1 цин нь 100 му буюу 6,144 га.

3Дай Сюецзи «1900 Нянь Нэй Мэйгу сибу дицюй гэцзу жэньминь Фаньди доучжэн» (1900 оны Өвөр Монголын баруун хэсгийн олон үндэстний ард түмний империализмыг эсэргүүцсэн тэмцэл)

«Лиши яньцзю» (Түүхийн судлал), Бээжин, 1960. № 6.

данзанванжил (1854—1907) ардын аман яруу найрагч Шагдар (1869— 1929) нарын зэрэг хүмүүс юм. Тэд Өвөр Монголын ард түмний тэмцлийн нөлөөгөөр өөрсдийн зохиол бүтээлийг туурвиж байв. Гэтэл тэдний дэвшилт үзэл санаа нь Өвөр монголчуудын үндэсний ухамсар сэргэх явдалд эргэн нөлөөлж байжээ.

Б. Тумэнжаргал

ВНУТРЕННЯЯ МОНГОЛИЯ ПОД МАНЬЧЖУРСКИМ господством

Р е з ю м е

Статья посвящена антиманьчжурской борьбе народа Внутренней Монголии в XVII—XIX вв. Автор рассматривает вопросы, связанные с политическим, экономическим и социальным положением Внутренней Монголии в период маньчжурского господства, с освободительной борьбой народа Внутренней Монголии против иноземных поработителей.

Завоевав Внутреннюю Монголию, маньчжуры прежде всего, внесли изменения в ее административную структуру, определили границу ее территории, куда вошли не все территории Внутренней Монголии, а только те, где было установлено маньчжурское господство. На этой территории был введен закон, согласно которому коренное население Внутренней Монголии не имело права свободно кочевать, и потому оно было лишено возможности вести борьбу против иноземных завоевателей совместными усилиями. Кроме того, маньчжуры установили ранги и титулы князей по мере преданности маньчжурской династии. Наряду с этим среди влиятельных монгольских феодалов поощрялись династийные браки и породнение с маньчжурской знатью,

Далее автор на основе большого фактического материала подробно останавливается на борьбе народа Внутренней Монголии против чужеземных поработителей на протяжении XVII—XIX вв. и на поддержке этой борьбы другими народами Монголии, в частности, халхасцами, ойратами и торгутами.

В статье даются конкретные данные относительно социально-экономического положения Внутренней Монголии XVII—XIX вв. Автор подчеркивает, что социально-экономическая политика маньчжуров сыграла роковую роль в истории Внутренней Монголии. В середине XIX в. освободительная борьба народа Внутренней Монголии приняла форму «дугуйланского» движения, которое было направлено не только против иноземных завоевателей и иностранных миссионеров, но и против местных феодалов. «Дугуйланское» движение, впервые возникшее в уезде Ушин Внутренней Монголии, наряду с другими формами борьбы, впоследствии влилось и переросло в национально-освободительную, общедемократическую и революционную борьбу монгольских народов, приведшая в конечном счете к свержению маньчжурского господства.